

## КОМПАНИЙН ДАМПУУРЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

С.Цолмон\*, Д.Моломжамц\*\*

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд компанийн дампуурал, түүний нийгэм-эдийн засгийн үр дагавар, дампуурлаас зайлсхийх боломжийн талаарх судлаачдын дэвшүүлсэн онол, арга зүй, үзэл баримтлалыг харьцуулан судалсан. Түүнчлэн өндөр хөгжилтэй орнуудын дампуурлыг зохицуулсан хууль эрх зүйн орчин, хууль тогтоомжийн онцлогийг судалж өөрийн орны холбогдох хууль эрх зүйн орчинтой харьцуулан дүгнэлт өгсөн болно.

**Түлхүүр үгс:** дампуурал, инноваци, өрсөлдөөн, дампуурлын тухай хууль

### A Study of the Theory of Bankruptcy

**Abstract:** In this article, corporate bankruptcy, its socio-economic consequences, theories, methods, and views put forward by researchers on the possibility of avoiding bankruptcy are compared. Additionally, the comparison between the bankruptcy of developed countries studying the regulated legal frameworks and the laws of our country with the relevant legal frameworks provided.

**Keywords:** bankruptcy, innovation, competition, bankruptcy law

---

\* МИС-ийн АТС, (E-mail): tsolmon@mandakh.edu.mn

\*\* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): molomjamts0112@yahoo.co.jp

Дампуурлыг компани нь бусдад төлөх ёстой өр төлбөрөө гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлж, барагдуулах боломжгүй байх агуулгаар ойлгохдоо энэ бүхний цаана нийгэм, ёс зүй, хүмүүний харилцаа, үүрэг хариуцлага, хууль эрх зүйгээс илүүтэй эдийн засгийн гүн гүнзгий учир холбогдол байдгийг иш үндэс болгох нь онол-арга зүйн хувьд нэн чухал. Хэдийгээр эдийн засгийн онолын түүхэн хөгжлийг эргэцүүлж үзвэл дампуурлын асуудлыг тусгайлан боловсруулахад бага анхаарсан мэт сэтгэгдэл төрөх боловч хэрэг дээрээ суурь онолын судалгаанд тодорхой үзэл чиглэлийн хүрээнд хөндсөн байдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Зарим судлаачид дампуурлын онол-арга зүйн үндсийг бүр сонгодог эдийн засгийн онолын хүрээнд боловсруулж зах зээлийн эдийн засгийн өөрийнх нь дотоод мөн чанар, зайлшгүй бүрэлдэхүүн институт гэж үзэж байна (Минакова, 2007). Сонгодог эдийн засгийн онолын төлөөлөгчид зах зээлийн эдийн засаг, өрсөлдөөний механизмын дотоод агуулга, хууль, зүй тогтуудтай асуудлыг холбож боловсруулах эхлэлийг тавьсан гэж үзэж болохоор байна.

Дампуурал гэсэн ойлголт нь бүр эртний Ромын хууль эрх зүйн системд тусгагдсан тэрхүү эдийн засаг, эрх зүйн утгаараа эдийн засгийн онолын судалгаанд хэрэглэгдэж байсан уламжлал өнөөг хүртэл үргэлжилж ирсэн билээ. Шинжлэх ухааны ойлголтын тухайд үгийн гарал үүсэл, этимологийн үндсийн талаар судлаачид харилцан адилгүй үзэл хандлагыг баримталж байгаа ч нэлээд нь итали гаралтай “banco”, “rotto” буюу “сандал”, “эвдэрхий” хэмээх хоёр үгээс үүсэлтэй гэж үздэг байна (Хурумов, 2007).

Орос хэлээр “банкротство” хэмээдэг нь дээрх санааг нотолж байна. Дампуурал нь зах зээлийн эдийн засгийн дотоод агуулгатай холбоотой, түүнээс үүсэлтэй үзэгдлийн хувьд юуны өмнө аж ахуй эрхлэх үйл ажиллагаа, аж ахуй эрхлэгч хүмүүс-энтерпренерүүдийн “төрөлх” чанарын зүй ёсны шинж, бүрэлдэхүүн хэсэг гэж сонгодог онолчид үзэж байсан билээ. Үүний цаана зах зээлийн өөрийнх нь агуулга, шинж чанар, механизм оршиж байдгийг тэд тэмдэглэж байв.

Компанийн дампуурал нь тодорхой аж ахуйн нэгж, аж ахуй эрхлэгч, өмчийн эзний асуудал мэт боловч хэрэг дээрээ энэ хүрээнээс хальж зөвхөн тодорхой салбар, нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй нийт эдийн засгийн хэмжээнд капитал, хөдөлмөр хэрхэн яаж аль болох ашигтай салбар, хүрээ рүү шилжиж хуваарилагдаж буйг харуулна. Энэ утгаар нь нийт үндэстний хэмжээнд баялаг хуваарилахад хүртэл капитал, хөдөлмөрийн шилжих хөдөлгөөнөөр дамжиж “дампуурал” зохих үүрэгтэй оролцдог талаар А.Смитын дэвшүүлсэн санаа, үндэслэл өнөөдөр ч гэсэн дампуурлын асуудлыг боловсруулж шийдвэрлэх онол-арга зүйн чухал чиг баримжаа болж байна гэж дүгнэх үндэстэй (Смит,

2006).

А.Смит болон сонгодог эдийн засгийн онолын бусад төлөөлөгчийн үзэл онолд дампуурал нь зах зээлийн ерөнхий механизм, өрсөлдөөнтэй олон талаар холбоотой болохыг ихээхэн дэлгэрэнгүй авч үзсэн төдийгүй түүний үндэс суурь шалтгааныг нээн харуулахад анхаарсан гэж үзэж болно. Тухайлбал, У.Петти, Д.Рикардо, А.Смит нарын боловсруулсан хөдөлмөрийн өртгийн онолыг орчин үеийн судлаачид эргэцүүлж нарийн шинжилж үзэхийн оронд К.Марксын онолын үндсэн суурь болсон гэдэг үндэслэлээр үгүйсгэж ирсэн тул энэ онолд дампуурлын дотоод шалтгаан, механизмыг тусгасан чухал үзэл санааг хүртэл нийтэд нь судалгааны гадна орхигдуулсан байна. Энэ буруу хандлагыг зарим судлаачид шүүмжилж зардал үндэслэлгүй нэмэгдэж бүтээмж дээшлүүлэх талаар бага анхаарч хэрэг дээрээ борлуулалт, санхүүгийн зах зээл зэрэг хөдөлмөрийн зардалтай бараг холбоогүй салбараас ашиг орлого хайж, үнэт цаас зэрэг “зохиомол” капиталыг хэт шүтэх буюу хөдөлмөрийн суурь үндсээс “тасарсан” аж ахуйн үйл ажиллагаа нь эцсийн дүндээ дампуурахад илүүтэй хүргэж буйг тэмдэглэж байна (Карен, 2010).

Тэгээд ч баялгийг юуны түрүүнд хөдөлмөр бүтээдэг тухай сонгодог онолчдын үзэл баримтлал нь аж ахуй эрхлэгчид байнга шинийг сэдэж санаачлах, шинэ үр ашигтай арга технологийг эрэлхийлэх, хийж бүтээх замаар л өрсөлдөөнд ялна, дампуурлаас зайлна хэмээх онолын үр дүнд хүргэсэн билээ. Үүнийгээ тэд инноваци буюу аж ахуй эрхлэгчид байх “төрөлх” чанар, тэд л өрсөлдөөнд ялж дийлэхийн тулд эрсдэл хийхээс ч айхгүй, байнга шинийг сэдэж санаачлахаас өөр аргагүй орчин нөхцөлд байдгаас үүсэлтэй чанар гэж тодорхойлсон байдаг нь дампуурлын утга агуулгыг ойлгох бас нэг үндэс гэж хэлж болох юм. Инновацийн онолыг үндэслэгчийн талаар өнөөг хүртэл маргаж байгаа боловч анх түүний талаар Францын сонгодог эдийн засгийн онолч Ж.Батист Сей хөндсөн. Тэрбээр өрсөлдөөний орчинд оршин тогтнох, нэг үгээр хэлбэл, дампуурлаас зайлсхийж өсөж дэвжих арга бол аж ахуй эрхлэгчид эрсдэлээс үл айж тасралтгүй инноваци хийх гэж үзэж байв. Бүр цаашлаад инноваци хийх чадвар дан ганц аж ахуй эрхлэгчдэд л байдаг хэмээн тодотгосон байна (Батист Сей, 2004).

Инноваци ба дампуурал хоёр нь эсрэг утгатай ойлголт боловч нэг л зүйлийн хоёр тал юм. Аж ахуйн байгууллага, аж ахуй эрхлэгчид инноваци хийх замаар л дампуурлаас зайлсхийж чадна. Харин инноваци хийдэг өөрсдийн энэ төрөлх чанар, давуу талаа алдвал дампуурахад хүрнэ. Мэдээж хэрэг инноваци хийх нь аж ахуй эрхлэгчдийн цорын ганц чанар, зорилго биш нь ойлгомжтой. Иймд аж ахуй эрхлэх, аж ахуй эрхлэгчдийн талаар сонгодог болон орчин үеийн эдийн засгийн онолын урсгал чиглэлд олон чухал онол-арга

зүйн үзэл баримтлалыг дэвшүүлж ирсэн билээ. Тухайлбал, инноваци хийхээс өөр аргагүй орчин нөхцөлд бараг л нийт аж ахуй эрхлэгчдийг тавих болсон нь өнөөгийн эдийн засгийн хөгжил, өрсөлдөөний онцлог гэдгийг Й.Шумпетер тэмдэглэж дампуурах аюулаас хэн ч зайлсхийх боломжгүй гэсэн дүгнэлт хийсэн юм. Түүний бодлоор инноваци бүхнийг хамраагүй эдийн засгийн орчинд ашиг орлого багатай, зардал өндөртэй ажилласан аж ахуй эрхлэгчид дампуурах аюулд өртөх боломжтой байснаа өнөөдөр шинэ үйлдвэрлэл, шинэ арга технологи, бүтээгдэхүүн боловсруулж сэдэж санаачлагчид зах зээлд улам гол үүрэгтэй болох тутам хэн ч дампуурах аюултай болж том, жижиг гэлтгүй аль байгууллага инноваци хийхгүй цаг алдвал дампуурах эрсдэлтэй. Үүнтэй холбогдоод Й.Шумпетер дампуурах аюул нь өнөөдөр өрсөлдөөний гол хөдөлгөгч хүч болон хувирч байгаа тул аж ахуй эрхлэгчид, пүүс, компаниуд ийм аюул нүүрлэхээс өмнө өөрчлөн байгуулалт хийж, огцом өөрчлөлт шинэчлэлийн арга хэмжээг авах нь зайлшгүй гэж үзсэн байна (Шумпетер, 1995). Өөрөөр хэлбэл урьдын адил дампуурах эхний шинж тэмдэг мэдрэгдэхийг хүлээх биш үүнээс хавьгүй өмнө инноваци хийх тухай ярьж байна.

Нобелийн шагналт эдийн засагч Ф.Хайек ч гэсэн өрсөлдөөний орчин үеийн хэв маяг, онцлогийг судлахдаа дампуурлын асуудлыг хөндсөн байна. Тэрбээр өрсөлдөөний эерэг болон сөрөг талыг харьцуулан шинжилж хэдийгээр өрсөлдөөний явцад дампуурал үүсэх ч түүнийг бас дампуурлаас урьдчилан сэргийлэх, дампууралд хүргэх нөхцөл, хүчин зүйлсийг тодорхой мэдэж илүү шинэ, үр ашигтай шийдвэр гаргах, урьд нь олж хараагүй эсвэл огт мэдэхгүй тийм арга замыг нээж ашиглах боломж гэдгийг тэмдэглэсэн нь өнөөгийн өрсөлдөөн ба дампуурлын учир холбоог нарийн судалж ойлгоход ач холбогдолтой. Ф.Хайек өрсөлдөөн дампууралд хүргэхээс гадна түүнээс зайлсхийх боломж агуулдаг бөгөөд өрсөлдөөн нь “түүнгүйгээр олж харахгүй эсвэл огт ашиглахгүй байсан тийм шинэ арга зам, нөхцөл боломжийг нээж” ажиллахад хүргэнэ гэж үзсэн юм (Хайек, 2009).

Зах зээлийн эдийн засгийн дотоод агуулга, хууль, зүй тогтлуудтай холбоотой, тэдгээрийн үргэлжлэл, илэрхийлэл гэж дампуурлыг үзэх нь онол-арга зүйн хувьд яах аргагүй зөв чиг хандлага мөн. Ийм үзэл санаа, үндэслэл дэвшүүлж буй судлаачидтай санал нэгтэй байгаа юм (Бойкова, 2011). Гэхдээ энэ санааг илүү тодруулж үзэх нь чухал. Энд хэд хэдэн чиглэлээр тодруулж болох ч үүнийг эдийн засгийн цикл хөдөлгөөн, зүй тогтолтой холбож тайлбарлах судлаачдын хандлага илүү ирээдүйтэй гэж бодож байна. Мэдээж эдийн засгийн цикл хөдөлгөөн нь урт удаан хугацаанд үргэлжлэх тул аж ахуйн нэгж байгууллага дээр буухдаа зохих онцлогтой боловч тэдний үйл ажиллагааны цикл хөдөлгөөнд ямар нэг хэмжээгээр оролцоно. Наад зах нь нийт эдийн

засаг, өрсөлдөөн, хөрөнгө оруулалт гээд бүхий л орчинг хамаарч тэдгээрийн хувьсал өөрчлөлтөөр дамжиж нөлөөлөх учир хямралаас бусад үед тэр болгон мэдрэгдэхгүй, аажим аж ахуйн нэгж, байгууллагын дотоод ажил амьдралд “оролцож” эхэлнэ. Тэр тусмаа шударга өрсөлдөх орчин хангалтгүй, аж ахуйн амьдралд төр засгийн оролцоо их, түүхий эдийн үнэ өртгөөс хамаарал ихтэй, байгалийн нөөц баялагтаа дулдуйдсан өрөөсгөл, эмзэг бүтэцтэй эдийн засагт цикл хөдөлгөөнд илүүтэй мэдрэмтгий, дампуурах боломж өндөртэй байна. Үүний өөр бусад шалтгааныг дурдаж болох ч хамгийн гол нь ийм эдийн засагт техник, технологийн бааз суурь ихээхэн хуучирсан, илт хоцрогдсон байдгаас болоод эдийн засгийн өөрийнх нь жам ёсны цикл хөдөлгөөн, гадаад орчны хурдацтай хувьсал өөрчлөлтийг гүйцэхгүй нийтээрээ дампуурах аюултай.

Ф.Хайек социализм нь зах зээлийн эдийн засаг, өрсөлдөөний эсрэг байгууламж гэдгийг тайлбарлахдаа техник, технологийн суурь үндсийн хувьсал хөгжилтэй холбоотой эдийн засгийн цикл хөдөлгөөний дарамт шахалтын дор дампуурах үндэсгүй мэт байсан эдийн засаг бүхэлдээ, түүнийг дагаад нийт салбар, аж ахуйн нэгж байгууллагууд нь дампуурсан болохыг тэмдэглэсэн байна (Пролог, 2009).

Нөгөө талаар эдийн засгийн цикл хөдөлгөөнтэй холбоотой дампуурлын асуудлыг судлахдаа сүүлийн үед аж ахуйн нэгж, байгууллагаар зогсохгүй нийгмийн дампуурлын тухай ярих болсныг бас анхаарахгүй орхиж болмооргүй санагдана. Одоогоор дампуурлын судалгаанд энэ асуудлыг тэр бүр хөндөлгүй орхиж байгаа боловч цаашдаа эдийн засгийн цикл хөдөлгөөний орон зай, цаг хугацаа ямар нэг хэмжээгээр хумигдаж нийгмийн техник, технологийн бааз суурь нь урьд байгаагүй хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй нь түүнийг шинэ өнцгөөс харж сэргээж боловсруулахыг шаардаж байна. Үндэсний эдийн засгийн дампуурлыг хүлээн зөвшөөрч түүнийг сэргээн босгож өөрчлөн байгуулсан хамгийн жишээ гэвэл өнгөрсөн зууны 20-иод оны сүүлч, 30-аад оны эхээр болсон дэлхий дахиныг хамарсан их хямралаас Америкийн эдийн засгийг гаргаж сэргээн босгосон АНУ-ын ерөнхийлөгчийн “Шинэ бодлого”-ыг нэрлэж болно. Энд нийт эдийн засгийг дампуурлаас аврахад чиглэсэн онцгой арга хэмжээг цогц байдлаар боловсруулж банк-санхүүгийн секторыг зохицуулахаас эхлээд онцгой байдлын бүхэл бүтэн багц хуулийг баталж хэрэгжүүлсэн байна (Негиши, 1995).

Үүнээс гадна аж ахуйн нэгж, байгууллагын өөрийнх нь амьдралын циклтэй холбож дампуурлын асуудлыг боловсруулах нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Энд ажил үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүний амьдралын циклтэй холбож дампуурлын учир шалтгааныг тайлбарлах гэсэн чиглэл нэлээд томоохон байр эзэлж байна. Түүнчлэн менежмент бүрэлдэж хөгжих цикл

болон байгууллагын удирдлагын ур чадвар, сэтгэлгээний хөгжлийн үе шаттай дампуурал бас цаагуураа нарийн учиг холбоостой гэдгийг иш үндэс болгож судлахад сүүлийн үед анхаарах боллоо. Тухайлбал, Америкийн судлаач И.Ансоф стратегийн удирдлагын онолыг үндэслэж боловсруулахдаа байгууллагын менежмент нь бүтээгдэхүүний амьдралын циклтэй яв цав тохирохгүй боловч ихээхэн төстэй цикл маягаар үүсэж бүрэлдэх тухай үзэл санааг дэвшүүлсэн бөгөөд тэр нь байгууллага дампуурах эсэхийг тодорхойлж байдгийг үндэслэсэн байна (Ансофф, 1989). Бүтээгдэхүүний амьдралын циклтэй нэлээд ойрхон муруй шугамаар байгууллагын менежмент хөгжих бөгөөд оргил цэгт хүрсэн мөчөөс түүнийг өөрчилж шинэчлэх ажлыг урьдаас бодож эхлэлийг тавихгүй орхивол тухайн байгууллагыг дампууралд хүргэх аюул тэр хэмжээгээр өсдөг болох нь өнөөдөр ч гэсэн дампуурлын учир шалтгааны дотор менежмент ямар үүрэг болохыг нарийн судалж ойлгоход ач холбогдолтой юм.

Эдийн засгийн онолд дампуурлын асуудлыг боловсруулахдаа түүний нийгэм-ёс суртахууны талыг хүртэл орхилгүй судалж боловсруулсан байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Тэгээд ч дампуурлын тухай ярих болоход энд эдийн засаг, нийгэм-улс төр, ёс суртахуун, хууль эрх гээд хүмүүний харилцааны олон хүрээ, талбар, учиг холбоос төвлөрч зангидсан байдаг болохоор практик дээр төдийгүй онол-арга зүйн судалгаа боловсруулалт хийхдээ хүртэл энэ бүхнийг анхаарах нь зүйтэй.

Сонгодог эдийн засагчид анх дампуурлын ёс суртахуун, сэтгэл зүйн талыг хөндөж байсан нь тэдний судалгаа ямар өргөн хүрээг хамаарч хэр гүнзгий учир холбогдолтой зэргийг нээж харахыг оролдсон болохыг илтгэж байна. Тухайлбал, А.Смит дампуурал нь орон зай, цаг хугацааны хувьд аж ахуйн нэгж, байгууллага, аж ахуй эрхлэгчид, тэнд ажиллагсдаар зогсохгүй түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, хангамжийн байгууллага, хүмүүсээс эхлээд ажил хэрэг, мөнгө санхүү, зохион байгуулалт, нутаг дэвсгэр, төрөл садан гээд л ямар нэг суваг, хэлбэрээр холбоотой бүхнийг хамарсан цар өргөн хүрээтэй харилцааны цогцыг хөндөж байдаг тул хүмүүст туйлын эмзэгээр хүлээн авдаг болохыг тэмдэглэсэн байна. Тэрбээр энэ тухай бичихдээ “дампуурах нь гэм зэмгүй хүмүүст тохиолдож болох хамгийн аймшигтай, хамгийн гутамшигтай зовлон шаналал юм. Иймээс хүмүүс түүнээс туйлын ихээр болгоомжилж явал дампуурлаас сэрэмжилж чадах вэ гэдэгт толгойгоо гашилгаж байдаг” гэжээ (Смит, 2006).

Дампуурал зах зээлийн эдийн засгийн дотоод агуулга, өрсөлдөөний арга механизмтай холбоотой төдийгүй аж ахуй эрхлэх цогц харилцааг байгууллага, аж ахуй эрхлэгчдийн оршихуй, эс оршихуй талаас нь хэрхэн тодорхойлдог талаас нь авч үзэв. Монгол улсад мөрдөгдөж байгаа, 1997 онд батлагдсан

Дампуурлын тухай хуульд хариуцагчийн үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн үнийн дүнгээс бусдад төлөх нийт зээл, өр төлбөрийг хассан зөрүүг түүний өөрийн хөрөнгө гэж тодорхойлоод “Өөрийн хөрөнгийн 10-с доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно” гэж заасан. Гэхдээ энэ нь хууль зүйн хувьд бүх өр төлбөрөө төлж чадахгүй байхыг хэлэхгүй, компанийн өөрийн хөрөнгийн 10 хувиас дээш хэмжээтэй үүргээ гэрээнд заасан хугацаанд биелүүлж чадахгүй байгааг тодруулсан байна.

Компанийн дампуурлыг хуурамч буюу зохиомол, азгүй тохиолдлын болон болгоомжгүй байдлаас үүссэн дампуурал гэсэн үндсэн 3 төрөлд хувааж үздэг. Үүнд:

- a. Хуурамч дампуурал нь зээлдүүлэгчийн өрийг төлөхөөс зугтах зорилгоор өөрийн хөрөнгийг санаатайгаар нуун дарагдуулах үйл ажиллагаа юм. Хуурамч дампуурал нь дотроо үндсэн 4 төрөлтэй байна. Үүнд:
  - Эд хөрөнгийг санаатайгаар нуун дарагдуулах;
  - Зээлийн картын залилан хийх;
  - Дутуу болон буруу мэдээлэл өгөх;
  - Өөр улс орны дампуурлын хуульд тохируулан дампуурлаа зарлах;
- b. Азгүй байдлын дампуурал нь инфляцийн өсөлт, байгалийн гамшиг, улс төрийн тогтворгүй байдал зэрэг урьдчилан тооцох боломжгүй хүчин зүйлээс үүддэг.

Болгоомжгүй байдлаас үүдэлтэй дампуурал нь байгууллагын удирдлагууд эрсдэлтэй үйл ажиллагаа явуулах, төсөл хөтөлбөр боловсруулах, шийдвэр гаргах зэргээс шалтгаалан үр ашиггүй үр дүн бий болох явдал юм (Моломжамц, 2012).

Хэрэв тухайн компани санаатайгаар буюу хуурамчаар дампуурсан нь тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгтэй, харин азгүй байдал болон болгоомжгүй байдлаас үүдэлтэй дампуурсан бол тухайн компанийг буцаан сэргээж хямралт байдлаас нь гаргах буюу өөрчлөн байгуулалт хийх хэрэгтэй.

Дампуурал нь зөвхөн компанийн түвшинд яригдах асуудал биш бөгөөд сүүлийн үед улс орны дампуурал, хувь хүний дампуурлын тухай ойлголтууд дэлхийн зарим улс оронд ихээр яригдах болжээ. Тиймээс дампуурал нь ямар нэг хэлбэрээр аж ахуй эрхэлж буй бүх субъектэд (*иргэн, өр гэр, байгууллага, улс орон г.м*) хамааралтай ойлголт болж байна. Хувь хүн (*Personal bankruptcy*) болон компанийн (*Corporate bankruptcy*) дампуурлын шалтгаан, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, зохицуулах хууль эрх зүйн зүйл, заалт зэрэг нь хэдийгээр

ялгаатай боловч зээлдүүлэгчдэд төлөх ёстой өр төлбөрөө гэрээний дагуу төлөх боломжгүй болсон байдал гэдэг дээр нэгдэж байна. Хувь хүний дампуурал нь компанийн дампууралтай төстэй боловч дампуурлын үндсэн шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, дампуурлаас гарах боломж зэрэг нь ялгаатай юм.

Дампуурлын харилцааг эрх зүйн харилцаагаар зохицуулдаг. Дампуурлын тухай анхны хууль 1542 онд Англи улсад батлагдаж байжээ. Энэхүү хууль нь зээлдүүлэгчдийн эрх ашгийг илүүтэй хамгаалсан, зээл авагчийг хатуу шийтгэх заалттай хууль байсан.

Зээлдүүлэгч нь өртэй хүнийхээ хөрөнгийг тодорхой нөхцөлийн дагуу хувааж авах боломжийг хуулиар зааж өгсөн. Хэрвээ зээлдэгч нь зээлдүүлэгчдэд төлөх өр төлбөрийг өөрийн хөрөнгөөр төлж чадахгүй бол шууд шоронд хоригдох заалтыг оруулж өгсөн хууль байсан. Улмаар энэхүү хуульд 1570 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

АНУ-д дампуурлын тухай бие даасан хууль 1787 онд батлагдсан. Үүнээс хойш АНУ-ын конгресс 1898 оныг хүртэл дампуурлын талаар 3 эрх зүйн актыг баталсан. /1800 он, 1841 он, 1898 он/ Үүний дараа 1938 онд нэмэлт өөрчлөлт орж, 14 бүлэгтэй шинэчлэгдэн батлагдсан. Улмаар 1970, 1978, 1979, 1986 онуудад тус бүр нэмэлт өөрчлөлт орж байсан бөгөөд 1994 онд шинэчлэн батлагдсан байна. 1978 оны акт нь өнөөдөр дампуурлын явцыг зохицуулж байгаа гол хууль болжээ. Учир нь энэ хууль компанийн дампуурлын тухай асуудлыг авч хэлэлцэхэд үндсэн чиглэл болж өгдөг.

Сүүлийн үед зарим улс орнууд хувь хүний дампуурлын тухай хууль батлан хэрэгжүүлэх болсон. Тухайлбал, ОХУ анх удаа хувь хүнд дампуурлаа зарлах боломжийг олгосон ба хувь хүний дампуурлын тухай хуулийг 2015 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. ингэснээр хувь хүн дампуурлаа зарлах боломжтой болж зээлийн тогтолцоонд өөрчлөлт орох боломжтой гэж үзсэн байна.

Харин улс орны дампуурлын гол шалтгаан нь донор орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл, өр төлбөрөө төлөх боломжгүй болох явдал буюу төсвийн болон төлбөрийн тэнцлийн хос алдагдал нь нэмэгдэж, улмаар өрийн үйлчилгээний үзүүлэлтүүдийн зохистой харьцаа нь сэрэмжлүүлэх түвшингээс давахад хүрдэг. Дэлхийн түүхэнд дэх зарим жишээг дурдвал, Мексикийн гадаад өр 1982 онд 80 тэрбум ам.доллар, ОХУ-ийн гадаад өр 1998 онд 17 тэрбум ам.доллар, Аргентины гадаад өр 2001 онд 145 тэрбум ам.доллар, Исландын гадаад өр 2008 онд 85 тэрбум ам.долларт тус тус хүрч байжээ.

Монгол улсад 1990 оноос өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед аж ахуйн нэгжийн дампуурал нь зөвхөн капиталист улс орнуудад байдаг,



харин социалист улс орнуудад дампуурал үүсэх нийгэм эдийн засаг, улс төрийн үндэслэлгүй хэмээн үздэг байсан. Энэ нь огт үндэслэлгүй зүйл биш юм. Учир нь нийгмийн өмч хөрөнгө улсын мэдэлд төвлөрч, төр ямар үйлдвэрлэл явуулж, хэдий хэмжээний бүтээгдэхүүнийг хэнд хэрхэн борлуулахыг төлөвлөгөөгөөр зохицуулдаг байв. Харин 1990 оноос хойш Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэнтэй холбоотойгоор төрийн өмч хувь хүн, аж ахуйн нэгжүүдийн мэдэлд шилжиж, улмаар компанийн дампуурлын тухай асуудал бодит зүйл болсон. Үүнээс үүдэн 1991 оны 6-р сарын 3-нд “*Аж ахуйн нэгжийн дампуурлын тухай хууль*” батлан хэрэгжүүлж эхэлсэн байна. Улмаар энэ хууль 1997 оны 11-р сарын 20-нд “*Дампуурлын тухай Монгол улсын хууль*” нэртэйгээр шинэчлэн батлагдсан. 1997 оны Дампуурлын тухай хуулиар хуучин хуулийнхаа нэрийг өөрчилсөн нь санамсаргүй зүйл биш юм. Учир нь энэ хуулийн дагуу дампуурсанд тооцогдох этгээд буюу хариуцагч нь төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, үүнээс гадна хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллага байна гэж үзсэн юм.

Дампуурлын үйл явц нь шүүх, түүнээс даалгавар авсан этгээдийн хараа хяналт дор явагддаг. Нэгд, хуулийн этгээдийг шүүхийн оролцоотойгоор дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө хэрэгжүүлж хэвийн үйл ажиллагааг нь сэргээх, хоёрт дампуурсанд тооцож татан буулгах үйл ажиллагаа юм.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-аас үйл ажиллагаа явуулдаг гишүүн орнууд дахь эрх зүйн орчинд цуврал үнэлгээ өгч, түүнийгээ байнга шинэчилж байдаг. Ингэхдээ хөрөнгийн зах зээл, компанийн тухай хууль, компанийн засаглал, концесс, дампуурал, барьцаат хэлцэл, болон харилцаа холбоо гэсэн хөрөнгө оруулалттай холбоотой тодорхой асуудалд төвлөрдөг.

Энэхүү үнэлгээг хийхэд хэрэглэдэг аргаар хүчин төгөлдөр хуулийн чанарыг “цаасан дээр байгаа байдлаар” (*экстенсив талаас*) нь, мөн тухайн хуулийн бодит хэрэгжилт (*ир дүнгийн хувьд*) гэсэн хоёр талаас нь үнэлдэг. ЕСБХБ-ны Дампуурлын үнэлгээний аргачлалын дагуу, Монгол улсын “*Дампуурлын тухай хууль*” нь олон улсын стандартад “*Муу нийцэж байна*” хэмээн үнэлэгдсэн (ЕСБХБ, 2006) байна.

Уг баримт бичиг 1997 онд батлагдсан дээрх хууль нь дампуурлын хэрэг үүсгэх, түүнээс үүдэж гарах маргаан шийдвэрлэх хэрэгсэл болж байгаа ч дампуурлыг шийдвэрлэх ажиллагаа болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, шүүхийн зохистой мэдлэг, туршлагын тухай асуудлууд маш дутмаг байгаа талаар дурджээ. Тус тайланд тусгагдсанаар бол “*Төлбөрийн чадваргүй байдалд орох гэдэг нь санхүүгийн цэцүлэлтээр тодорхойлогддог, гэтэл хуульд өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний өрийн цүргээ хууль*

буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно гэсэн нь ойлгомжгүй байна. Энд нарийвчилсан тодруулга хийх шаардлагатай, ялангуяа хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах тодорхой зааж өгөх хэрэгтэй” гэж дүгнэсэн байна.

АНУ-ын төрийн департаментас (Гадаад худалдаа, үйлчилгээ ба АНУ) 2015 онд гаргасан улс орнуудын гадаад худалдааны “Монгол Улсад бизнес эрхлэх нь” хэмээх тайланд Монгол улсад бизнес хийх боломж, тэр дундаа эдийн засаг, хууль эрх зүйн орчны талаар тусгажээ. Энэхүү тайланд гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхдог гол асуудлын нэг нь тухайн улсад үйлчилж буй компанийн дампуурлын тухай хууль байдаг. Гэвч Монгол улсад үйлчилж буй дампуурлын тухай хуулийн зүйл заалт нь ойлгомжгүй, зарим шаардлагатай зүйлийг орхигдуулсан байдгаас гадна шүүхийн шийдвэр гүйцэтгэх процесс нь хүндрэлтэй, хөдлөх хөрөнгийг зээлийн барьцаанд тооцох тогтолцоо бүрдээгүй зэрэг асуудал байгаа талаар дурдсан байна.

Мөн Кроллын бизнесийн мэдээлэл судалгааны хэлтсийн удирдах зөвлөлийн дарга Жак Клод-ийн “Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх боломж ба эрсдэл” нийтлэлд мөн гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд бизнесийн орчин, хууль эрх зүйн мэдээлэл дутмаг, тэр дундаа хөрөнгө оруулах компани нь шүүхээр орж байсан, эсвэл дампуурч байсан зэрэг мэдээллийн сан нь нээлттэй байдаггүй, мөн дампуурлын тухай хууль нь тодорхойгүй байдаг гэж дүгнэсэн байна (Jack, 2011).

Эдгээр нь гадаадын хөрөнгө оруулагч, олон улсын санхүүгийн байгууллагууд болон судлаачдын зүгээс манай улсад үйлчилж буй 1997 оны дампуурлын тухай хуульд зарим шаардлагатай зүйл заалт нэмэх, одоо байгаа зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах, тодорхой болгох шаардлагатайг харуулж байна. Иймээс манай улсын дампуурлын тухай хуулийн дараах дутагдлыг залруулах, тодорхой бус байдлыг арилган сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

- Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дампуурч байгаа компанийн санхүүгийн байдлын талаар мэдээлэл авах механизмыг хуульд тусгаагүй;
- Гадна, өртэй этгээд, эсвэл өртэй этгээдийн өмчийг эзэмшдэг гуравдагч этгээдийг итгэмжлэгдэгчтэй хамтран ажиллахыг хуулиар шаарддаггүй;
- Хүчин төгөлдөр бус хэлцэл, тухайн хөрөнгийн үнээс доогуур үнээр хэлцэл хийх зэрэгтэй холбоотой заалтууд тодорхойгүй;
- Тодорхойлогдоогүй нэр томъёо болон зорилгыг тогтоох шаардлага дээр үндэслэгдсэн;
- Тодорхой нэхэмжлэгчдэд давуу эрх олгосон байж болзошгүй хэлцлийг хянан шалгах хугацааг дампуурлын хэрэг үүсгэхээс өмнөх 120 хоногоор

хязгаарласан нь хэтэрхий богино бөгөөд урвуулан ашиглах боломжийг олгодог;

- Бүтцийн өөрчлөлтийн санхүүжилтийн асуудал мөн хуульд тусгагдаагүй орхигдсон;

*Дампуурлын хэлцэл болон өөрчлөн байгуулалт:* Компанийн дампуурлыг сайн дурын (*voluntary bankruptcy*) болон сайн дурын бус (*involuntary bankruptcy*) дампуурал гэж ангилна. Сайн дурын дампуурал нь төлбөрийн чадваргүй болсон учир дампуурсанд тооцохыг хүсэж тухайн хуулийн этгээд шүүх болон харилцагч талдаа өөрөө мэдэгдэх явдал юм. Харин сайн дурын бус дампуурал нь тухайн хуулийн этгээд төлбөрийн чадваргүй буюу үүргээ гүйцэтгэхээс татгалзсан гэж үзэж, түүнийг дампуурсанд тооцуулахаар харилцагч этгээд шүүхэд нэхэмжлэл гаргана гэсэн үг юм. Компани төлбөрийн чадваргүй болсон буюу дампуурсан тохиолдолд зээлдүүлэгчидтэй сайн дурын хэлцэл хийж болно. Энэ нь хуулийн дагуу компанийг дампууруулахад гардаг олон зардлаас зайлсхийх боломжийг олгоно.

Компанийн өөрчлөн байгуулалтын үйл явцад төлбөр хариуцагчийн үүрэг их байдаг. Юуны өмнө компанийн хөрөнгө активын үнэлгээг хийж, өөрчлөн байгуулалт хийх үндсэн нөхцөл байдлыг тодорхойлно. Өөрчлөн байгуулалтын төлөвлөгөөний үндсэн хэсэг нь компанийн капиталын бүтцийн өөрчлөлтөд чиглэсэн байдаг. Хамгийн эхэнд төлбөр гүйцэтгэх дээд ангиллын өр төлбөрт шинээр гаргах үнэт цааснаас эхний ээлжид олгох ба бусад өр төлбөрт дарааллаар нь олгож хамгийн сүүлд хувьцаа эзэмшигчдэд үлдсэн хэсгийг хуваарилна. Корпорацын өөрчлөн байгуулалт дараах 5 үе шатыг дамжина. Үүнд:

1. Дампуурлын хуулийн дагуу өөрчлөн байгуулалт хийх хүсэлтийг шүүхэд хандана. Энэ хүсэлтийг зээлдүүлэгчид гаргасан ба хариуцагч компани эсэргүүцсэн бол шүүх хэргийг хэлэлцэж, компани үнэхээр төлбөрийн чадваргүй болсон эсэхийг тогтооно.
2. Компани төлбөрийн чадваргүй болсон нь шүүхээр тогтоогдвол дампуурлыг зарлах ба зээлдүүлэгчдийн хүсэлтээр итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг томилж болно. Энэ итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийн хөрөнгө актив, үйл ажиллагаанд хяналт тавина. Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилоогүй тохиолдолд компани шүүхийн хяналтын дор өөрчлөн байгуулалтын үйл ажиллагааг эрхлэн явуулна.
3. Төлбөр хариуцагч компани өөрчлөн байгуулалтын иж бүрэн төлөвлөгөөг гаргаж шүүхэд танилцуулна. Төлөвлөгөөг шүүх хэлэлцэж үнэлгээ өгч, зөвшөөрөн батлах эсвэл татгалзах шийдвэр гаргана.
4. Шүүхээс өөрчлөн байгуулалт хийх төлөвлөгөөг хэрэгжих үндэслэлтэй

гэж үзээд зөвшөөрөн баталсан тохиолдолд компанийн зээлдүүлэгчид ба хувьцаа эзэмшигчдийн зөвлөгөөнөөр нарийвчлан хэлэлцээд хэрэгжүүлэх шатанд орно.

5. Өөрчлөн байгуулалтын төлөвлөгөөг шүүхээр хэлэлцэж баталсны дараа төлөвлөгөөг хэлэлцэхэд оролцсон талууд зардлын тайлан гаргана.

Шүүх компанийн төлбөрийн чадваргүй болсныг тогтоож өөрчлөн байгуулалт хийх боломжгүй гэж үзсэн тохиолдолд дампуурлыг зарлаж үйл ажиллагааг нь зогсоож, дуусгавар болгох шийдвэр гаргана. Компанийн үйл ажиллагааг бүр мөсөн зогсоож дампуурлын хэргийг эрхлэх итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг томилно. Итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийн хөрөнгийг хяналтдаа авч зээлдүүлэгчид, нэхэмжлэгчдийн эрх ашгийг хамгаална. Итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийн хөрөнгийг худалдаж борлуулан бүртгэл хөтөлж, нэхэмжлэгчдийн хүсэлтийг барагдуулж, эцсийн тооцоо хийж тайлан гаргана. Хэрэв компанийг өөрчлөн байгуулах боломжгүй болсон бол татан буулгана. Компани үнэ цэнэгүй болж, санхүүгийн уналтаас гарах ямар ч боломжгүй болсон, хэрэв үйл ажиллагаа нь үргэлжилбэл зээл олгогчид ихээхэн алдагдал учирч өндөр эрсдэл хүлээх болсон үед компанийг татан буулгаж дараах арга хэмжээг авах ёстой. Үүнд:

1. Дампуурсан компанийн эзэмшигчид хөрөнгийг хулгайлахаас сэргийлэх
2. Зээл олгогчид зээлийн хэмжээтэй тэнцэх хөрөнгийн хуваарилалт хийх
3. Чадваргүй болсон зээл авагчдыг үүргээс нь чөлөөлнө

Хөрөнгийг борлуулсны орлого, барьцаат зээлдүүлэгчдийн төлбөрийг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй бол төлбөрийн үлдсэн хэсгийг ердийн зээлдүүлэгчдийн өр төлбөртэй нэгэн адил хувь тэнцүүлэх замаар тооцож олгоно.

Барьцаат зээлдүүлэгчдийн барьцаа хөрөнгийг зарж борлуулсан орлого, төлөх ёстой төлбөрийн хэмжээнээс давсан тохиолдолд давсан орлогыг ердийн зээлдэгчдийн төлбөрийг гүйцэтгэхэд зориулна. Тухайлбал, АНУ-д дампуурсан компанийн хөрөнгийг дараах зориулалтаар хуваарилдаг. Үүнд:

- Хамгаалагдсан зээл олгогчид тодорхой хэмжээний хөрөнгийг олгогдсон эрхийн дагуу зарж зээлсэн мөнгөө олж авна;
- Дампуурсан компанийн зохицуулалтын үйл ажиллагаа гүйцэтгэсэн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн зардлыг төлнө;
- Дампуурлыг зарласны дараа гарах зардлын жагсаалтыг гаргана;
- Ажилчдын цалинг олгоно;
- Ашигтай төлөвлөлтөд оролцож байсан албан хаагчдын цалинг олгоно;
- Захиалагчийн депозитын хамгаалагдаагүй үүргийн төлбөрийг хийнэ;
- Улсын, орон нутгийн татварын тооцоог хийнэ;

- Тэтгэврийн сангийн тооцоо хийнэ;
- Хамгаалалтгүй зээл олгогчдын тооцоо хийнэ;
- Давуу эрхтэй хувьцаа эзэмшигчтэй хувьцааны нэрлэсэн үнээр тооцоо хийнэ;
- Хамгийн сүүлд энгийн хувьцаа эзэмшигчдийн төлбөрийг гүйцэтгэнэ.

Монгол улсын дампуурлын тухай хуульд хариуцагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай 3-р бүлэгт заасан хэдий ч дахин хөрөнгөжүүлэлт нь өөрчлөн байгуулалт хийх олон арга замуудын нэг хэсэг юм. Дахин хөрөнгөжүүлэлт гэдэгт төлбөрийн чадваргүй аж ахуйн нэгжид ямар нэгэн замаар нэмэлт, шинэ хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, өр төлбөрөө барагдуулахыг ойлгоно. Өөрчлөн байгуулалт нь шинээр хөрөнгөжүүлэхэд байгаа биш, харин талуудын харилцан тохиролцоо, хамтын шийдэлд оршино. Баялаг болон зардал хэмнэлтийн талаас харвал өөрчлөн байгуулалт талуудад ба нийт эдийн засагт аль алинд нь ашигтай юм.

Нэг компанийг дуусгавар болгоод оронд нь шинийг бүтээн босгох нь илүү зардалтай байдаг. Татан буулгаж дуусгавар болгосон бол эргэлт буцалтгүй, нийгэм, нийт эдийн засагт хэчнээн үнэтэй цогц хөрөнгө үгүй болох нь зүйн хэрэг юм. Д.Р.Коробкин аль нэг бизнесийн ажиллагаатай байдал ба ажиллах чадварыг хадгалж үлдсэнээр үгүй болгочихсон бол хэзээ ч биелэхгүй байсан зорилгуудыг биелүүлж болох тухай бичжээ (Коробкин, 1993). Мөн амжилтгүй болсон өөрчлөн байгуулалтын зардал татан буулгалтын нийт эдийн засагт учруулах хохирлоос илүү гарах нь ховор байдаг.

### **Дүгнэлт**

Судлаачдын бүтээлд тулгуурлан компанийн дампуурал, түүний үндсэн шалтгаан, дампуурлыг урьдчилан таамаглахын ач холбогдол болон компанийн дампуурлыг таамаглах загваруудын талаар судалж дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Аль ч улсад үйлчилж буй дампуурлын тухайн хууль нь компанийн дампуурлыг албан ёсоор зарлахад баримталдаг гол эрх зүйн акт болж байгаач манай улсад хэрэгжиж буй хуулийн зарим зүйл заалт нь ойлгомжгүй, шаардлагатай зүйлийг орхигдуулсан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх процесс нь хүндрэлтэй, хөдлөх хөрөнгийг зээлийн барьцаанд тооцох тогтолцоо бүрдээгүй зэрэг олон дутагдал байгаа тул илүү боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэв;
- Аж ахуйн нэгжийн өрсөлдөөн хийгээд дампуурал нь зах зээлийн

харилцаанд зайлшгүй байх нийгмийн үзэгдэл боловч байх ёстой хэмээн төрөөс зөнд нь орхиж болохгүй. Өндөр хөгжилтэй зарим улсад дампуурлын тухай асуудалд төрөөс илүү их анхаарал хандуулах болсныг харгалзан үзэх шаардлагатай байна;

- Компани дампуурч болзошгүй байдлаа урьдчилсан таамаглах боломжтой бөгөөд үүний үр дүнд тухайн компани учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, түүний хор хөнөөлийн эсрэг компанийн дархлааг удирдах боломжтойгоос гадна энэ нь хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид, засгийн газар зэрэг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд чухал ач холбогдолтой асуудлын нэг болсон гэж дүгнэж байна.

### **Ашигласан материал**

- Ансофф, И. (1989). *Стратегическое управление*. С. 78-82.
- Батист Сей, Ж. (2004). *Улс төрийн эдийн засгийн ухааны шинжилгээ*. Орч. УБ.
- Бойкова, А. (2011). *Преодоление экономической несостоятельности предприятия в рамках антикризисного управления*. Автореферат ...докт.эк.наук. М., С. 7-8.
- Бригхэм, Ю., & Гапенски, Ж. (1999). *Финансовый менеджмент: полный курс/ пер. с англ.* СПб. Экономическая школа: С. 54.
- Карен, М. (2010). *Богатство народов: Новая интерпретация экономической классики*. Минск: "Попурри", с. 67-88.
- Маевский, В. (1994). *Кондратьевские циклы. Экономическая эволюция и экономическая генетика.*: М.: ИЭ РАН.
- Минакова, И. (2007). *Теория и методология формирования и модернизации института банкротства*. . Автореферат. док. эк.наук. Орел. С. 5-8.
- Негиши, Т. (1995). *История экономической теории*. Пер. с англ. М.,: С. 124.
- Пролог, Ф. (2009). *Экономическая теория*. М., ИРИСЭН: С. 109. .
- Рафиков, Р. (2003). *Банкротство модель возрождения. Экономический анализ: теория и практика*. №9, - с. 51.
- Смит, А. (2006). *Үндэстнцүдийн баялаг*, Орч. УБ: 56 дахь тал.
- Хайек, Ф. (2009). *Экономическая теория* . С. 45.
- Хурумов, П. (2007). *Банкротство: что это такое?* Журнал управления

компанией, №6, с. 72-74.

- Шумпетер, Й. (1995). *Капитализм, социализм и демократия*. Экономика, С 87.
- Jack, C. (2011). *“Investing in Mongolia: Opportunities and risks”*. Hong Kong: Managing director in Kroll’s Business Intelligence & Investigations division in Hong Kong.
- Lim, T. C. (2012). Bankruptcy Prediction: Theoretical Framework Proposal . *International Journal of Management Sciences and Business Research* , ISSN (2226-8235).